

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Долоодугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”* гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт *“Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн”* гэж тус тус заасан байна. Мөн Үндсэн хуулийн Гучиннаймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад Засгийн газар *“шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого”*-ыг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх” үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна.

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 1.2-т *“Энэ хуулийн зорилт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, уг үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хувийн хэвшлийн оролцоо, төрийн дэмжлэг, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино”* гэж, 23.1-д *“Засгийн газар төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлд санхүүжилтийн дэмжлэг олгоно”* гэж тус тус заасан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6.5 дахь хэсэгт Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Хөгжлийн зорилтот хөтөлбөр байх бөгөөд үүнд *“шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөр”* орохоор байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим” хэсгийн 1.2.3-т “Монгол Улсын “оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал”, “хүний аюулгүй байдал”, “хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал”, **“шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал”** харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна” гэж, “Эдийн засгийн олон тулгуурт бүтэц” хэсгийн 3.2.1.7-д *“Шинжлэх ухааны шинжилгээ, судалгаа, инновацийг стратегийн ач холбогдолтой салбаруудад төвлөрүүлж, эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлнэ”* гэж, 3.2.1.8-д *“Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхыг хөгжүүлнэ”* гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.4-т “Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацийн тогтолцоог хөгжүүлнэ” гэж заасан бөгөөд энэ зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн I үе шат (2021-2030) буюу Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон

хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлэх үе шатанд (1) Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр-шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчин бүрдсэн байна гэж, (2) Шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх дэд бүтцийг өргөжүүлж, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоотой болсон байна гэж тус тус заасан байна.

Мөн тус тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.1.27-д “Шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд дээд боловсролын сургалтын байгууллагуудын оруулах хувь, нэмэр, оролцоог нэмэгдүүлж, бүс нутагтаа өрсөлдөх чадвартай үндэсний судалгааны их сургууль байгуулна” гэж, 2.4.4-т “Шинжлэх ухаан, инновацын салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэл бий болгож, гадаадын дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлнэ” гэж, 2.4.5-д “Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын эрх зүйн орчныг шинэчилж, инновацын үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн тусгай зориулалтын сангуудыг байгуулна. 2.4.15.Шинжлэх ухаан, технологийн санг олон улсын адил төстэй сангуудын жишиг, хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөн зохион байгуулна” гэж, 2.4.16-д “Эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургуулийг сургалт, судалгаа хөгжүүлэлт, инновацын төв болгон хөгжүүлнэ” гэж, 2.4.17-д “Аж ахуйн нэгж, олон нийтэд инновац, гарааны бизнес эхлүүлэх боловсрол олгох, инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, технологи, танин мэдэхүйн төрөл бүрийн агуулга бүтээх ажлыг дэмжинэ” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын 3.6.д “Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ” гэж заасан байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4-т зааснаар Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах бөгөөд тус мэдээлэлд 8.4.26 дахь хэсэгт зааснаар “төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээлэл”, болон 8.4.27 дахь хэсэгт зааснаар “мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан” тус тус орохоор байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Шинжлэх ухаан, технологи, инновац гэсэн 3.3.7 дахь хэсгийн 3.3.7.1-д “Шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг дотоодын

нийт бүтээгдэхүүний 1 хувьд хүргэж, шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ” гэж, 3.3.7.5-д “Мэдээлэл, харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам, тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг салбарт нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ” гэж, 3.3.7.7-д “Үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн сангийн MORI платформыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэдлэгийн дата төв байгуулна” гэж тус тус заасан байна.

1.2.Практик шаардлага

Тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Эрдэм шинжилгээний байгууллагыг төрийн, хувийн, хамтарсан өмчийн хэлбэрээр байгуулж болно.*” гэж 18.2-т “*Эрдэм шинжилгээний байгууллагад дараах байгууллага хамаарна:*

18.2.1.энэ хуулийн 3.1.3-т заасан шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа эрхэлдэг хүрээлэн, төв, лаборатори;

18.2.2.Дээд боловсролын тухай хуулийн 22.4-т заасан эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага;

18.2.3.шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл;

18.2.4.төрийн болон орон нутгийн музей.” гэж тус тус заасан байна.

Дээрх зохицуулалтаас 18 дугаар зүйлийн 18.2.2-т “*Дээд боловсролын тухай хуулийн 22.4-т заасан эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага*” гэдэгт тодорхой шалгуур үзүүлэлт хангасан эрдэм шинжилгээний хүрээлэн бүхий их сургуулийг хамааруулсан нь хэт явцуу байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д “Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад **улсын төсвөөс санхүүждэг** хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ” гэж, түүнчлэн тус хуулийн 13 дугаар зүйлд Төрийн өмчит хуулийн этгээдэд 1/ төрийн байгууллага, албан газар; 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар; 3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг; 4/төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/” тус тус ангилан авч үзсэнээс үзвэл, төрийн өмчит хуулийн этгээд болох төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага болон бүх шатны сургалтын байгууллага нь улсын төсвөөс санхүүждэг болно.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “төсвийн захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх” гэж тус тус зааснаас үзвэл төрийн өмчийг барьцаалах, баталгаа гаргах зохицуулалтыг хориглосон байна.

Түүнчлэн төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагуудын зардал нь урьдчилсан төлөвлөгдсөн байдаг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулагдах тендер шалгаруулалтад тухайн байгууллагууд оролцоход урьдчилан төсөв гаргах боломжгүй байдаг.

Гэтэл эдгээр байгууллагуудыг төрийн худалдан авах ажиллагаанд оролцоход Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тендерийн баталгаа бүрдүүлэн оролцох шаардлагатай болдог, түүнчлэн шалгарсны дараа тус хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг шаардахаар

байгаа нь тэдний хувьд төрийн аливаа тендерт оролцох нөхцөл, боломжийг хязгаарладаг байна.

Хэдийгээр Шинжлэх ухаан, технологийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 31.5-д “Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.11-т заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй” гэж заасан боловч энэ дараах зүйлүүдээс шалтгаалан нийтлэг байдлаар хэрэгжих боломжгүй байна. Үүнд:0

1.Захиалагчийн хувьд Засгийн газар болон төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэж нэр заасан явдал нь бүх захиалагчдыг хамрахгүй байна.

2. Мөн энэхүү зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэхгүй байх цар хүрээнд оруулахгүй бол дангаараа хэрэгжих магадлал багатай байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.26, 8.4.27-д зааснаар Мэдээлэл хариуцагч “төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээлэл”, болон “мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан”-г байнга ил тод, нээлттэй байлгах үүрэгтэй боловч энэ зохицуулалт практикт нэг мөр хэрэгжихгүй байна.

Түүнчлэн төсвийн хөрөнгөөр захиалагч бүр янз бүрийн төрлийн судалгааны ажлыг хийдэг боловч тэдгээрийг нэг дор төвлөрүүлсэн дата бааз байхгүй байгаагаас судалгаа шинжилгээний ажлыг төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд давхардуулан хийлгэж төсвийн үргүй зардал гаргах үр дагаврыг бий болгож байна.

Хэдийгээр <https://sudalгаа.gov.mn/> гэсэн үндэсний судалгааны нэгдсэн платформыг үүсгэсэн боловч тус платформд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн судалгааны ажлыг бүрэн гүйцэд нэгтгэн оруулж чадаагүй байна.

Мөн үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээллийн нэгдсэн санг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хариуцуулж, УИХ-д энэхүү нэгдсэн сантай холбоотой хийж гүйцэтгэсэн ажлыг тайлагнадаг зохицуулалтыг оруулахгүй бол практикт хэрэгжихгүй хэвээрээ байхаар байна.

Дээр дурдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 4 зүйлээс бүрдэх ба тэдгээрт дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

1. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага нь тухайн байгууллагын судалгааны үндсэн чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсан сонгон шалгаруулалтад оролцоход тендерийн болон гүйцэтгэлийн баталгаанаас чөлөөлөх тухай зохицуулалтыг тусгана;

2. Үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн санг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэдлэгийн дата төв байгуулж ил тод байлгах зохицуулалтыг тусгах бөгөөд үүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 буюу захиалагчийн эрх үүрэгт судалгааны ажлыг ил тод байлгах үүргийг тусгах байдлаар ингэхдээ энэхүү үүргээ ШУТ сангийн цахим хуудаст байршуулах, шинээр MORI платформ үүсгэн байгуулах, tendergov.mn сайтад байршуулах, эсхүл <https://sudalгаа.gov.mn/> гэсэн үндэсний судалгааны нэгдсэн платформд байршуулах замаар шилэн болгох зохицуулалтыг тусгана. Үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээллийн нэгдсэн санг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хариуцуулж, УИХ-д энэхүү нэгдсэн сантай холбоотой хийж гүйцэтгэсэн ажлыг тайлагнадаг зохицуулалтыг оруулна.
3. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2-ийг “Дээд боловсролын тухай хуулийн 4.1.4-т заасан судалгааны их сургууль” гэж өөрчилсөн;
4. Хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгээс “Үндэсний хорооны тогтоол, зөвлөмжийг үндэслэн” гэсэн агуулгыг хасах тухай заалт оруулсан.
5. Дагаж мөрдөх хугацааны талаарх зохицуулалтыг тусгана.

Гурав. Хууль батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагууд төрийн худалдан авах ажиллагаанд оролцоход тендерийн болон гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй болно.

Түүнчлэн төсвийн хөрөнгөөр захиалагч бүр янз бүрийн төрлийн судалгааны ажлыг хийлгэдэг боловч тэдгээрийг нэг дор төвлөрүүлсэн дата бааз байхгүй байгаагаас шалтгаалан судалгаа шинжилгээний ажлууд энд тэнд давхардуулан хийж төсвийн үргүй зардал гарах үр дагаврыг арилгана.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Шинжлэх ухааны академийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---